



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 1/30

Улаанбаатар хот

Шинжээч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч З.Түвшинтөгсийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 104/Ш32020/00038 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголросцветмет” ТӨҮГазарт холбогдох, Баянзүрх дүүргийн 12-р хороо, Жанжины 28-р гудамж 737 тоотод оршин суух Хонхэрээд овогт Банзрагчийн Энхбат /РД:СЦ64061312/-ын нэхэмжлэлийн шаардлагад үүссэн, “Монголросцветмет” ТӨҮГазрын харъяа “Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэр”-т хадгалагдаж буй нэхэмжлэлд дурдсан бүтээлд шинжилгээ хийлгэх тухай иргэний хэрэгт тус газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бат-Эрдэнийг шинжээчээр томилсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР